МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000383940

2018.02.07	9071086095
/ Бүртгэсэн он,сар,өдөр /	/ Хувийн хэргийн дугаар /
	1022504
	/ Регистрийн дугаар /

Монголын усан спорт сонирхогчдын холбоо — Холбоо /НҮТББ/

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол	01	1999.03.24
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /

9499	Усан спорт сонирхогч иргэдийн авъяас, ур чадварыг нээн хөгжүүлэх, тамирчид бэлтгэх, сургалт, уралдаан, тэмцээн зохион байгуулах, ижил зорилготой байгууллагуудтай хамтран ажиллах
/ Код/	/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй	1	0.00
/ хугацаа /	/ гишүүдийн тоо /	/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, МҮОХ-ны төв байр, 115 тоот, Утас1: 88131777, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ Э.БАТОЧИР

/тэмдэг/ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2026 он 11 сар 11 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Раднаа овогтой Бадрах-г Удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* *Цэен овогтой Энхжавхлан-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.*	*2026.11.11* *2026.11.11*	*Э.Баточир* *Э.Баточир*
2	*Дахин гэрчилгээ олгов.*	*2026.11.11*	*Э.Баточир*

УЛСЫН БҮРТГЭГЧ 620

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000383940

МУССХ-ны Их хурлаар 2026 оны
10 сарын 10-ны өдөр шинэчлэн найруулав

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

(Шинэчилсэн найруулга)



Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Байгууллагын нэр нь “Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо” товчлол нь МУССХ (цаашид Холбоо гэх) англи хэлээр: Mongolia Aquatics товчлол нь MA

1.2. Холбоо нь 1991 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан.

1.3. Холбооны төв нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана. Холбооны албан ёсны хаягийг Удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтоож, хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1.4. Холбоо нь Монгол Улсад усан спортыг хөгжүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, гишүүнчлэлтэй, төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.

1.5. Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийг баримтлан үйл ажиллагаагаа явуулна.

1.6. Холбоо нь Монгол Улсын усан спортыг үндэсний болон олон улсын түвшинд төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics), Азийн усан спортын холбоо (Asia Aquatics) болон өөрийн гишүүнчлэл бүхий бусад олон улсын спортын байгууллагатай хамтран ажиллаж, тэдгээрийн гишүүнчлэлийн хүрээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлнэ.

1.7. Холбоо нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд World Aquatics, Asia Aquatics, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA)-ийн хүчин төгөлдөр дүрэм, код, стандарт, журам болон холбогдох шийдвэрийг дагаж мөрдөнө. Холбооны дүрэм, журамд өөрөөр заасан нь дээрх олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хүрээнд заавал мөрдөх хэм хэмжээг зөрчих үндэслэл болохгүй.

1.8. Холбоо үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бие даасан, хараат бус байх, ардчилсан засаглал, шударга өрсөлдөөн, ил тод байдал, хариуцлага, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хүний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, жендэрийн тэгш байдлыг хангах, тамирчны эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хүүхэд, өсвөр үеийн тамирчны эрх ашгийг хамгаалах зарчмыг баримтална.

1.9. Энэхүү дүрмийн аливаа заалт Монгол Улсын хууль тогтоомжтой зөрчилдвөл Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. World Aquatics, Asia Aquatics болон WADA-ийн дүрэм, код, стандарт, журамд өөрчлөлт орсон тохиолдолд Холбоо олон улсын гишүүнчлэлийн үүрэг болон Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн дүрэм, журмыг зохих журмын дагуу шинэчилнэ.

Хоёр. ХОЛБООНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Холбооны эрхэм зорилго нь Монгол Улсад усан спортыг тогтвортой хөгжүүлэх, хүртээмж, оролцоог нэмэгдүүлэх, тамирчдын ур чадвар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, олон улс, тив, дэлхий, олимпын наадамд өрсөлдөх амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх, үндэсний болон олон улсын түвшинд усан спортын нэр хүнд, амжилтыг ахиулахад оршино.

2.2. Холбоо нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1 Монгол Улсад усан спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

2.2.2 Усан спортоор хичээллэх хүүхэд, залуучууд, иргэдийн оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлж, клуб, орон нутаг болон тамирчдын хөгжлийг дэмжих

2.2.3 Өсвөр үе, залуучууд болон өндөр амжилт гаргах тамирчдыг үе шаттайгаар бэлтгэх тогтолцоог хөгжүүлж, үндэсний шигшээ багийн залгамж халаа, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

2.2.4 Олимпын наадам, Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээн, бусад олон улсын тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн оролцох тамирчдын бэлтгэл, сонгон шалгаруулалт, оролцоог дэмжиж, олон улсын түвшинд тогтвортой амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлэх;

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

2.2.5 Дасгалжуулагч, шүүгч, техникийн ажилтан болон усан спортын бусад мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, олон улсын түвшний мэдлэг, ур чадвар эзэмшихийг дэмжих;

2.2.6 World Aquatics, Asia Aquatics болон бусад холбогдох олон улсын, бүс нутгийн спортын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж, сургалт, хөгжлийн хөтөлбөр, төсөл, тэмцээн, арга хэмжээнд идэвхтэй оролцох;

2.2.7 Усан спортын сургалт, дасгалжуулалт, спортын шинжлэх ухаан, судалгаа, инновац, мэдээлэл, технологийн хөгжил, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх;

2.2.8 Шударга өрсөлдөөн, спортын ёс зүй, допингийн эсрэг зарчим, тамирчны эрүүл мэнд, аюулгүй байдал, хүүхэд хамгаалал болон дарамт, хүчирхийллээс ангид спортын орчныг бий болгох;

2.2.9 Усан спортын клуб, салбар холбоо, гишүүн байгууллага болон бусад оролцогч талуудын үйл ажиллагаа, хамтын ажиллагааг дэмжиж, үндэсний хэмжээнд усан спортын нэгдсэн хөгжлийн тогтолцоог бүрдүүлэх;

2.2.10 Усан спортын үндэсний болон олон улсын тэмцээн, сургалт, арга хэмжээг зохион байгуулах, дэмжих, тэдгээрийн зохион байгуулалтын чанар, стандартыг тасралтгүй дээшлүүлэх;

2.2.11 Усан спортыг олон нийтэд сурталчлан таниулах, түүний эрүүл мэнд, боловсрол, хүмүүжил, нийгмийн ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх;

2.2.12 Холбооны үйл ажиллагаанд сайн засаглал, ил тод, шударга байдал, тэгш оролцоо, хариуцлагын зарчмыг хэрэгжүүлж, усан спортын тогтвортой хөгжлийг хангах.

Гурав. ХОЛБООНЫ ҮҮРЭГ

3.1. Холбоо нь эрхэм зорилго, зорилтоо хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд World Aquatics, Asia Aquatics, WADA-ийн холбогдох дүрэм, код, стандарт, журмыг дагаж мөрдөнө.

3.2. Монгол Улсад усан спортын төрлүүдийг хөгжүүлэх урт, дунд хугацааны бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах, үнэлэх;

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

3.3. Усан спортын үндэсний хэмжээний тэмцээн болон бусад арга хэмжээг зохион байгуулах, тэдгээрийн нэгдсэн календарь, стандарт, шаардлагыг тогтоож хэрэгжүүлэх;

3.4. World Aquatics-ийн хүчин төгөлдөр техникийн болон тэмцээний дүрэм, стандартыг үндэсний хэмжээнд мөрдүүлэх, шаардлагатай үндэсний журам, зааврыг батлан хэрэгжүүлэх;

3.5. Монгол Улсыг Олимпын наадам, Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээн, бусад олон улсын тэмцээн, арга хэмжээнд төлөөлөх үндэсний шигшээ баг, тамирчдыг ил тод, шударга, урьдчилан баталсан шалгуурын дагуу сонгон шалгаруулж оролцоог хангах, бэлтгэл сургуулилтыг зохион байгуулах;

3.6. Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, техникийн ажилтан болон усан спортын бусад мэргэжилтний бүртгэл, зэрэглэл, лиценз, мэргэшлийн тогтолцоог холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулах;

3.7. Дасгалжуулагч, шүүгч, техникийн ажилтан болон бусад мэргэжилтний мэдлэг, ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх сургалт, семинар, хөгжлийн хөтөлбөрийг зохион байгуулах, World Aquatics, Asia Aquatics-ийн сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулах;

3.8. Тамирчдын үндэсний дээд амжилт, тэмцээний үр дүн, статистик, бүртгэл мэдээллийг хөтөлж, үндэсний дээд амжилтыг холбогдох журмын дагуу баталгаажуулах, олон улсын байгууллагад шаардлагатай мэдээллийг хүргүүлэх;

3.9. World Aquatics, Asia Aquatics, Монголын Үндэсний Олимпын Хороо, төрийн захиргааны болон бусад үндэсний, олон улсын байгууллагатай хууль тогтоомж, дүрмийн хүрээнд хамтран ажиллах;

3.10. World Aquatics, Asia Aquatics болон бусад гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, шаардлагатай тайлан, бүртгэл, мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлэх;

3.11. World Anti-Doping Code, World Aquatics-ийн допингийн эсрэг дүрэм болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн допингийн эсрэг үйл ажиллагаа, сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжин хэрэгжүүлэх;

3.12. Тамирчин, ялангуяа хүүхэд, өсвөр үеийн тамирчны эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төрийг хамгаалж, дарамт, хүчирхийлэл, ялгаварлан

гадуурхалт болон бусад зохисгүй үйлдлээс ангид спортын аюулгүй орчныг бүрдүүлэх;

3.13. Спортын шударга байдал, ёс зүй, шударга өрсөлдөөнийг хангаж, авлига, тэмцээний үр дүнд хууль бусаар нөлөөлөх, ашиг сонирхлын зөрчил болон бусад спортын шударга байдлыг алдагдуулах үйлдлээс урьдчилан сэргийлэх;

3.14. Гишүүн байгууллага, салбар холбоо, клуб, тамирчин, дасгалжуулагч, шүүгч болон бусад оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг дүрэм, журмын хүрээнд хамгаалж, тэгш, шударга оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

3.15. Холбооны үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, санхүү, төсөв, тайлангийн ил тод байдлыг хангаж. хариуцлага, сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх;

3.16. Холбооны хөрөнгө, санхүүжилт, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг зөвхөн дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаанд зориулан үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийн дагуу санхүүгийн бүртгэл, тайлан гаргах;

3.17. Усан спортын хөгжлийг дэмжих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, ивээн тэтгэгч болон бусад оролцогч талтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.18. Усан спортын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, спортын ач холбогдлыг сурталчлан таниулах, хүүхэд, залуучууд болон иргэдийн усан спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх;

3.19. Холбооны гишүүдийн бүртгэл, мэдээллийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хөтөлж, хувийн мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хангах;

3.20. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. ХОЛБООНЫ ЭРХ

4.1. Холбоо нь дүрэмд заасан эрхэм зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн дараах эрхийг хэрэгжүүлнэ.

4.2. Монгол Улсад усан спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх, өөрийн эрх хэмжээний хүрээнд батлан хэрэгжүүлэх;



4.3. Усан спортын үндэсний хэмжээний тэмцээн болон бусад арга хэмжээний нэгдсэн календарь, зохион байгуулалтын журам, стандарт, шалгуур үзүүлэлтийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.4. Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд World Aquatics, Asia Aquatics-ийн хүчин төгөлдөр тэмцээний болон техникийн дүрэм, стандартыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, тэдгээрт нийцсэн үндэсний дүрэм, журам, заавар батлах;

4.5. Монгол Улсыг Олимпын наадам, Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээн, бусад олон улсын тэмцээн, арга хэмжээнд төлөөлөх үндэсний шигшээ баг, тамирчин, дасгалжуулагч болон багийн бусад албан тушаалтныг нээлттэй журмын дагуу сонгон шалгаруулж нэр дэвшүүлэх;

4.6. Монгол Улсад зохион байгуулагдах усан спортын үндэсний болон олон улсын тэмцээн, сургалт, семинар, хөгжлийн хөтөлбөр болон бусад арга хэмжээг зохион байгуулах, хамтран зохион байгуулах, зохион байгуулах эрх олгох;

4.7. Усан спортын клуб, салбар холбоо болон бусад гишүүн байгууллагыг энэхүү дүрэм, холбогдох журмын дагуу гишүүнээр элсүүлэх, бүртгэх, тэдгээрийн статус, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх;

4.8. Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, техникийн ажилтан болон усан спортын бусад мэргэжилтнийг бүртгэх, ангилал, зэрэглэл, лицензийн тогтолцоог бий болгох, холбогдох шалгуур, журмыг батлах, эрх хэмжээнийхээ хүрээнд лиценз, зэрэглэл олгох;

4.9. Тамирчны үндэсний дээд амжилт, тэмцээний үр дүнг холбогдох дүрэм, журмын дагуу хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, бүртгэх, нийтэд мэдээлэх;

4.10. Хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарахаас бусад тохиолдолд тамирчин, дасгалжуулагч, шүүгч болон усан спортын бусад мэргэжилтэнд спортын цол, зэрэг, шагналд нэр дэвшүүлэх, Холбооны өөрийн шагнал, зэрэглэл, өргөмжлөл олгох;

4.11. Холбооны дүрэм, ёс зүйн дүрэм, тэмцээний дүрэм болон бусад дотоод хэм хэмжээг зөрчсөн гишүүн, тамирчин, дасгалжуулагч, шүүгч, албан тушаалтанд холбогдох дүрэм, журмын дагуу сахилгын ажиллагаа явуулах, эрх бүхий хараат бус байгууллагын шийдвэрийн үндсэн дээр зохих арга хэмжээ авах;



4.12. Сахилгын болон бусад шийдвэр гаргахдаа тухайн этгээдэд зөрчлийн талаар мэдэгдэх, тайлбар, нотлох баримт гаргах, сонсогдох болон шийдвэрийг давж заалдах боломжийг холбогдох дүрэм, журмын дагуу хангах;

4.13. World Aquatics, Asia Aquatics, Монголын Үндэсний Олимпын Хороо болон бусад үндэсний, олон улсын байгууллагад Холбоог төлөөлөх, тэдгээрийн хурал, сонгууль, комисс, зөвлөл, сургалт, хөтөлбөр болон бусад үйл ажиллагаанд төлөөлөгч нэр дэвшүүлэх, томилох;

4.14. World Aquatics, Asia Aquatics болон бусад олон улсын байгууллагын тэмцээн, сургалт, хөгжлийн хөтөлбөр, төсөл, санхүүжилтэд оролцох, хүсэлт гаргах, холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах;

4.15. Усан спортын хөгжлийг дэмжих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага болон бусад хуулийн этгээдтэй хамтран ажиллах, хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ, санамж бичиг байгуулах;

4.16. Холбооны зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг хуульд зөвшөөрсөн эх үүсвэрээс бүрдүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хандив, дэмжлэг, ивээн тэтгэлэг авах, тэдгээрийг зориулалтын дагуу зарцуулах;

4.17. Холбооны үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан эрх хэмжээ, журмын хүрээнд өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

4.18. Усан спортын сургалт, судалгаа, мэдээлэл, статистик, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа болон бусад контент, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, түгээх, хууль тогтоомжид нийцүүлэн оюуны өмчийн эрхээ хамгаалах;

4.19. Холбооны нэр, бэлгэ тэмдэг, лого, тэмдэг, албан ёсны тэмцээн болон бусад оюуны өмч, арилжааны эрхийг хууль тогтоомжийн дагуу эзэмших, ашиглах, хамгаалах, бусдад ашиглуулах эрх олгох;

4.20. Холбооны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг Монгол Улсын шүүх, төрийн байгууллага, World Aquatics, Asia Aquatics болон бусад эрх бүхий байгууллагын өмнө хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын дагуу хамгаалах;

4.21. Холбооны эрхэм зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөл, комисс, ажлын хэсэг болон бусад бүтцийг энэхүү дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд байгуулах;

УЛСЫН БҮРТГЭГЧ 520

4.22. Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Холбооны гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагын дүрэм, журмаар зөвшөөрсөн бусад эрхийг хэрэгжүүлнэ.

Тав. ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

5.1. Холбоо нь сайн дурын гишүүнчлэлтэй байна.

5.2. Холбооны эрхэм зорилго, үндсэн зарчим, дүрэм, холбогдох журмыг хүлээн зөвшөөрсөн, усан спортыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клуб, байгууллага болон усан спортын үйл ажиллагаанд оролцогч иргэн энэхүү дүрэм, гишүүнчлэлийн журмын шаардлагыг хангасан тохиолдолд Холбооны гишүүн байж болно.

5.3. Холбооны гишүүнчлэл нь дараах хэлбэртэй байна:

5.3.1 Гишүүн клуб, байгууллага;

5.3.2 Салбар холбоо;

5.3.3 Хувь гишүүн;

5.3.4 Хүндэт гишүүн.

5.4. Гишүүнээр элсэх, бүртгэх, гишүүнчлэлийг шинэчлэх, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох, гишүүний татвар, бүртгэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг энэхүү дүрэмд нийцүүлэн баталсан “Гишүүнчлэлийн журам”-аар зохицуулна.

5.5. Холбоонд гишүүнээр элссэн хувь хүн нь Гишүүнчлэлийн үнэмлэх, энгэрийн тэмдэгтэй, харин клуб нь гэрчилгээтэй байна.

5.6. Гишүүнчлэлтэй холбоотой аливаа шийдвэр нь ил тод, шударга, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд үндэслэнэ.

5.7. Гишүүн клуб

5.7.1 Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд усан спортын нэг буюу хэд хэдэн төрлөөр тамирчин бэлтгэх, сургалт, дасгалжуулалт, тэмцээн болон хөгжлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд Холбооны гишүүн клуб байж болно.

5.7.2 Гишүүн клуб нь Холбооны дүрэм, журам, ёс зүйн болон тамирчны аюулгүй байдлын шаардлагыг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөнө.

5.7.3 Гишүүн клуб нь тамирчин, дасгалжуулагч болон бусад гишүүн этгээдийн бүртгэлийг үнэн зөв хөтөлж, Холбоонд тогтоосон журмын дагуу мэдээлнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

5.7.4 Гишүүн клуб нь Холбооны албан ёсны тэмцээн, үйл ажиллагаанд тамирчнаа оролцуулах, Холбооны сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамрагдах болон энэхүү дүрэмд заасан бусад эрхийг эдэлнэ.

5.7.5 Гишүүн клубыг элсүүлэх, бүртгэх, ангилах, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, дуусгавар болгохтой холбоотой нарийвчилсан шалгуур, журмыг Удирдах зөвлөл батална.

5.8. Салбар холбоо

5.8.1 Холбоо нь усан спортын хөгжлийг орон нутаг болон бүсчилсэн хөгжлийн чиглэлээр дэмжих зорилгоор энэхүү дүрэмд нийцүүлэн салбар холбоог хүлээн зөвшөөрч, бүртгэж болно.

5.8.2 Салбар холбоо нь Холбооны эрхэм зорилго, дүрэм, бодлого, стандарт, ёс зүйн болон тамирчны аюулгүй байдлын шаардлагыг дагаж мөрдөнө.

5.8.3 Салбар холбоо өөрийн үйл ажиллагааг зохицуулах дотоод журамтай байж болох бөгөөд уг журам нь энэхүү дүрэм болон Холбооны эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамтай зөрчилдөхгүй байна.

5.8.4 Салбар холбоо нь өөрийн удирдлага, үйл ажиллагаа, гишүүнчлэл болон санхүүгийн мэдээллийг Холбоонд тогтоосон журмын дагуу тайлагнана.

5.8.5 Салбар холбоо байгуулах, хүлээн зөвшөөрөх, бүртгэх, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, статусыг түдгэлзүүлэх, сэргээх болон дуусгавар болгох нарийвчилсан зохицуулалтыг Удирдах зөвлөлөөс баталсан журмаар тогтооно.

5.8.6 Нэг нутаг дэвсгэр, нэг бүсчилсэн хөгжлийн чиглэлээр ижил статус бүхий салбар холбоог давхар бүртгэх эсэх болон тэдгээрийн төлөөллийн зохицуулалтыг Холбооны бүтэц, хөгжлийн бодлогод нийцүүлэн тусгай журмаар зохицуулна.

5.9. Хувь гишүүн

5.9.1 Холбооны эрхэм зорилго, үндсэн зарчим, дүрмийг хүлээн зөвшөөрсөн Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Холбооны хувь гишүүнээр элсэж болно.

5.9.2 Насанд хүрээгүй тамирчны бүртгэл, гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг Монгол Улсын хууль тогтоомж болон Холбооны хүүхэд

хамгаалал, тамирчны аюулгүй байдлын бодлого, журмын дагуу зохицуулна.

5.10. Хүндэт гишүүн

5.10.1 Монгол Улсын усан спортын хөгжил болон Холбооны үйл ажиллагаанд онцгой хувь нэмэр оруулсан Монгол Улсын болон гадаад улсын иргэнийг Холбооны хүндэт гишүүнээр өргөмжилж болно.

5.10.2 Хүндэт гишүүнээр өргөмжлөх шалгуур, нэр дэвшүүлэх болон шийдвэрлэх журмыг Удирдах зөвлөл батална.

5.10.3 Хүндэт гишүүн нь гишүүний татвар төлөхгүй бөгөөд энэхүү дүрэмд тусгайлан заагаагүй бол Их хуралд саналын эрхгүй байна.

5.11. Гишүүнээр элсэх

5.11.1 Гишүүнээр элсэх хүсэлтэй хувь хүн Холбооны гишүүнчлэлийн маягтыг бөглөж, гишүүнчлэлийн татварыг төлснөөр гишүүн болсонд тооцно.

5.11.2 Гишүүн клуб, салбар холбоог гишүүнээр элсүүлэх эсэх асуудлыг Гишүүнчлэлийн журамд заасан эрх бүхий бүтэц, албан тушаалтан тогтоосон шалгуурын дагуу шийдвэрлэнэ.

5.11.3 Гишүүнээр элсүүлэхээс татгалзсан бол үндэслэлийг хүсэлт гаргагчид бичгээр буюу цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

5.11.4 Гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэрийг хүсэлт гаргагч Гишүүнчлэлийн журамд заасан хугацаа, журмын дагуу давж заалдах эрхтэй.

5.12. Гишүүдийн бүртгэл

5.12.1 Холбоо гишүүдийн нэгдсэн бүртгэл хөтөлнө.

5.12.2 Гишүүдийн бүртгэлд гишүүний төрөл, статус, элссэн огноо, төлөөлөх эрх, гишүүнчлэлийн татварын төлөв болон шаардлагатай бусад мэдээллийг тусгана.

5.12.3 Холбоо гишүүдийнхээ мэдээллийг Монгол Улсын хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн дагуу хадгалж, зөвхөн албан хэрэгцээндээ ашиглана.

5.13. Гишүүний татвар

5.13.1 Холбооны гишүүн нь энэхүү дүрэм болон Гишүүнчлэлийн журамд заасан гишүүний татварыг тогтоосон хугацаанд төлнө.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

5.13.2 Гишүүний төрөл тус бүрийн татварын хэмжээ, төлөх хугацаа, хөнгөлөлт, чөлөөлөлт болон татвартай холбоотой бусад нөхцөлийг эрх бүхий бүтэц батална.

5.13.3 Гишүүний татвар болон гишүүнчлэлийн бусад орлогыг Холбооны санхүүгийн бүртгэлд бүрэн тусгаж, зөвхөн дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаанд зарцуулна.

Зургаа. ГИШҮҮНИЙ ЭРХ

6.1. Холбооны гишүүн нь гишүүнчлэлийн төрөл, статус болон энэхүү дүрэмд заасан хүрээнд дараах эрх эдэлнэ.

6.1.1 Холбооны үйл ажиллагаанд оролцох, Холбооны бодлого, стратеги, хөтөлбөр, дүрэм, журам болон усан спортын хөгжлийн асуудлаар санал, хүсэлт, санаачилга гаргах;

6.1.2 Энэхүү дүрэмд заасан шаардлага хангасан тохиолдолд Холбооны Их хуралд төлөөлөгчөөр оролцох, санал өгөх;

6.1.3 Энэхүү дүрэм болон сонгуулийн холбогдох журамд заасан шаардлага хангасан тохиолдолд Холбооны сонгуульт албан тушаалд нэр дэвших, сонгох, сонгогдох;

6.1.4 Холбооноос зохион байгуулах болон зөвшөөрөл олгосон тэмцээн, сургалт, семинар, хөгжлийн хөтөлбөр болон бусад арга хэмжээнд холбогдох шалгуур, журмын дагуу оролцох;

6.1.5 World Aquatics, Asia Aquatics болон бусад үндэсний, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт, хөгжлийн хөтөлбөр, төсөл болон бусад боломжид тогтоосон шалгуурын дагуу нэр дэвших, хамрагдах;

6.1.6 Холбооны үйл ажиллагаа, батлагдсан бодлого, дүрэм, журам, тэмцээний календарь, сонгон шалгаруулалтын шалгуур болон нийтэд нээлттэй бусад мэдээллийг авах;

6.1.7 Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой асуудлаар Холбооны эрх бүхий бүтцэд хүсэлт, гомдол гаргаж, шийдвэрлүүлэх;

6.1.8 Өөрт хамаарах сахилгын болон гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэхээс өмнө тухайн асуудлын үндэслэлтэй танилцах, тайлбар, нотлох баримт гаргах, сонсголд оролцох;

6.1.9 Өөрт нь холбогдох шийдвэрийг энэхүү дүрэм болон холбогдох журмын дагуу давж заалдах;

УЛСЫН БҮРТГЭГЧ 520

6.1.10 Гишүүнчлэлээс сайн дураар гарах;

6.1.11 Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Холбооны холбогдох журмаар олгосон бусад эрхийг эдэлнэ.

6.2. Холбооны гишүүдийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нас, хэл, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, хөгжлийн бэрхшээл болон хуульд хориглосон бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.3. Гишүүний саналын эрх, сонгох, сонгогдох эрх нь гишүүнчлэлийн төрөл, статус, татварын хэмжээ болон энэхүү дүрэмд заасан бусад шаардлагаас хамаарч болох бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг энэхүү дүрэм болон холбогдох журмаар тогтооно.

Долоо. ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

7.1. Холбооны гишүүн дараах үүргийг хүлээнэ:

7.1.1 Монгол Улсын хууль тогтоомж, Холбооны дүрэм, эрх бүхий бүтцээс баталсан дүрэм, журам, шийдвэрийг дагаж мөрдөх;

7.1.2 World Aquatics, Asia Aquatics, WADA-ийн өөрт хамаарах дүрэм, код, стандарт, шаардлагыг дагаж мөрдөх;

7.1.3 Холбооны эрхэм зорилго, зорилтыг дэмжиж, Монгол Улсад усан спортыг хөгжүүлэхэд өөрийн боломжийн хүрээнд бодит хувь нэмэр оруулах;

7.1.4 Спортын шударга өрсөлдөөн, ёс зүй, хүндлэл, тэгш оролцооны зарчмыг баримтлах;

7.1.5 Тамирчин, дасгалжуулагч, шүүгч, албан тушаалтан болон бусад оролцогчийн нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

7.1.6 Хүүхэд, өсвөр үеийн тамирчин болон бусад оролцогчийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалахтай холбоотой Холбооны бодлого, журмыг дагаж мөрдөх;

7.1.7 Допингийн эсрэг дүрэм, спортын шударга байдлыг хамгаалах болон тэмцээний үр дүнд хууль бусаар нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх холбогдох шаардлагыг дагаж мөрдөх;

7.1.8 Өөрт үүссэн бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг нүүн дарагдуулахгүйгээр холбогдох журмын дагуу мэдэгдэх;

7.1.9 Гишүүний татвар болон дүрэм, журмын дагуу тогтоосон бусад төлбөрийг хугацаанд нь төлөх;

7.1.10 Холбоонд бүртгүүлсэн өөрийн болон байгууллагын мэдээллийг үнэн зөв байлгаж, өөрчлөлт орсон тохиолдолд тогтоосон хугацаанд мэдээлэх;

7.1.11 Холбооны нэр, лого, бэлгэ тэмдэг болон бусад оюуны өмчийг зөвшөөрөлгүй буюу Холбооны нэр хүнд, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах хэлбэрээр ашиглахгүй байх;

7.1.12 Холбооны болон бусад гишүүний үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулах, хуурамч мэдээлэл, баримт бичиг бүрдүүлэх, тэмцээн, сонгууль, бүртгэл болон бусад ажиллагааны шударга байдалд санаатайгаар нөлөөлөх үйлдэл гаргахгүй байх;

7.1.13 Холбооны үйл ажиллагааны явцад олж авсан нууцад хамааруулсан болон хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй задруулахгүй байх;

7.1.14 Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Холбооны холбогдох журмаар хүлээлгэсэн бусад үүргийг биелүүлнэ.

Найм. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ, ГИШҮҮНИЙ ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ ТУХАЙ

8.1. Гишүүнчлэл дараах үндэслэлээр дуусгавар болно:

8.1.1 Гишүүн өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс гарсан;

8.1.2 Хувь гишүүн нас барсан;

8.1.3 Гишүүн хуулийн этгээд татан буугдсан буюу хуульд заасан журмаар үйл ажиллагаа нь дуусгавар болсон;

8.1.4 Энэхүү дүрэмд заасан үндэслэл, журмын дагуу гишүүнчлэлээс хассан.

8.2. Гишүүн өөрийн хүсэлтээр гарах бол Холбоонд бичгээр эсвэл цахим хэлбэрээр мэдэгдэнэ. Гишүүнчлэл дуусгавар болох нь тухайн гишүүний өмнө үүссэн төлбөр, хариуцлага болон бусад биелэгдээгүй үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.3. Дараах нөхцөлд гишүүнчлэлийн эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болно:

8.3.1 Гишүүний татварыг тогтоосон хугацаанд төлөөгүй;

8.3.2 Гишүүний үүрэг болон бусад заавал биелүүлэх шаардлагыг биелүүлээгүй;



8.3.3 Дүрэм, ёс зүй, аюулгүй байдал, тэмцээний дүрэм болон бусад холбогдох журмын зөрчлийг шалгаж байгаа бөгөөд түр арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай;

8.3.4 World Aquatics, Asia Aquatics, WADA болон хуульд заасан эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрээр тухайн этгээдийн эрхийг түдгэлзүүлсэн;

8.3.5 Энэхүү дүрэм болон Гишүүнчлэлийн журамд заасан бусад үндэслэл бий болсон.

8.4. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх шийдвэрт түдгэлзүүлсэн үндэслэл, хугацаа, тухайн хугацаанд хязгаарлагдах эрх болон эрх сэргээх нөхцөлийг тодорхой тусгана.

8.5. Түдгэлзүүлэх үндэслэл арилсан, шаардлагатай үүргээ биелүүлсэн тохиолдолд гишүүнчлэлийн эрхийг холбогдох журмын дагуу сэргээнэ.

8.6. Дараах ноцтой буюу давтан зөрчил гаргасан тохиолдолд гишүүнийг гишүүнчлэлээс хасах асуудлыг шийдвэрлэж болно:

8.6.1 Монгол Улсын хууль тогтоомж, Холбооны дүрэм, ёс зүйн дүрэм болон бусад заавал дагаж мөрдөх хэм хэмжээг ноцтой буюу удаа дараа зөрчсөн;

8.6.2 Холбоо, усан спорт, тамирчин болон бусад оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд санаатайгаар ноцтой хохирол учруулсан;

8.6.3 Тэмцээний үр дүн, сонгууль, бүртгэл, лиценз болон Холбооны бусад ажиллагаанд залилан, хууран мэхлэлт, хуурамч баримт бичиг ашигласан;

8.6.4 Хүүхэд хамгаалал, дарамт, хүчирхийлэл, ёс зүй, спортын шударга байдалтай холбоотой ноцтой зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

8.6.5 Допингийн эсрэг дүрмийн зөрчил гаргасан бөгөөд энэ нь холбогдох эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрээр батлагдсан;

8.6.6 Зөрчлийг арилгах талаар өгсөн шаардлагыг үндэслэлгүйгээр биелүүлээгүй;

8.6.7 Энэхүү дүрэм болон холбогдох журамд гишүүнчлэлээс хасах үндэслэл гэж тусгайлан заасан бусад ноцтой зөрчил гаргасан.

8.7. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгохтой холбоотой энэ дүрмээр нарийвчлан зохицуулаагүй харилцааг энэхүү дүрмийн зарчимд нийцүүлэн баталсан Гишүүнчлэлийн журмаар зохицуулна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГИЙН ТУСЛАХ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Ес. МУССХ-НЫ УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1. МУССХ-ны удирдлагын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

9.1.1 Холбооны Их Хурал

9.1.2 Хяналтын зөвлөл - 3

9.1.3 Ерөнхийлөгч буюу Холбооны Удирдах зөвлөлийн дарга

9.1.4 Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

9.1.5 Дэд Ерөнхийлөгч – 4

9.1.6 Удирдах зөвлөлийн гишүүн - 9

9.1.7 Хүндэт Ерөнхийлөгч

9.1.8 Ерөнхий нарийн бичгийн дарга

9.1.9 Усан спортын аль нэг төрлийг дагнан хариуцсан хороо

9.1.10 Аймаг, нийслэлийн болон бүсийн салбар холбоо

9.2. Холбооны Удирдах зөвлөл дэргэдээ Тамирчдын, Дасгалжуулагчдын, Шүүгчдийн, Ёс зүйн зөвлөлүүдтэй байна. Зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү дүрмийн хүрээнд Удирдах зөвлөлөөс гаргасан бие даасан журмаар зохицуулна.

9.3. Холбоо нь Эрдэм шинжилгээний судалгаа, Гадаад харилцаа, Мэдээлэл сурталчилгааны багтай байж болно.

Арав. ХОЛБООНЫ ИХ ХУРАЛ

10.1. Их хурал нь Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбооны эрх барих дээд байгууллага мөн.

10.2. Их хурал нь эрх барих дээд байгууллагын хувьд Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн бүрэн эрхэд шууд хамааруулснаас бусад бүх бүрэн эрхийг хэрэгжүүлэх онцгой эрхтэй байна.

10.3. Их хурлыг хоёр (2) жилд нэг удаа, сонгуульт Их хурлыг 4 жил тутамд 1 удаа хуралдуулна. Их хурал хуралдах товыг нэг (1) сараас доошгүй хугацааны өмнө Холбооны Удирдах зөвлөл тогтооно.

10.4. Их хурлаар дараах үндсэн асуудлыг хэлэлцэж тогтоол гаргана. Үүнд:

10.4.1 Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах,

10.4.2 Холбооны хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох,

10.4.3 Холбооны үйл ажиллагааны тайлантай танилцаж, хүлээн авах,

10.4.4 Холбооны санхүүгийн тайлантай танилцаж, хүлээн авах,



10.4.5 Усан спортын аль нэг төрлийг дагнан хариуцсан салбар хороодын үйл ажиллагааны тайлантай танилцаж хүлээн авах,

10.4.6 Холбооны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийдөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг батлах,

10.4.7 Холбоог татан буулгах болон үлдэгдэл хөрөнгийг хуваарилах асуудлыг шийдвэрлэх,

10.4.8 Их хуралаар хэлэлцүүлэхээр Удирдах зөвлөлөөс оруулсан бусад асуудлууд.

10.5. Их хуралд дараах этгээдүүд саналын эрхтэй оролцоно.

10.5.1 Ерөнхийлөгч

10.5.2 Хүндэт Ерөнхийлөгч

10.5.3 Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

10.5.4 Дэд Ерөнхийлөгчид

10.5.5 Удирдах зөвлөлийн гишүүд

10.5.6 Салбар холбоод- тус бүр 1

10.5.7 Гишүүн клубуудын төлөөлөл – 5

10.5.8 Дасгалжуулагчдын зөвлөлийн төлөөлөл- 1

10.5.9 Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөл- 1

10.5.10 Тамирчдын төлөөлөл- 3

10.5.11 Олон Улсын Хэмжээний Мастер тамирчид

10.5.12 Пара тамирчдын төлөөлөл-1

10.5.13 Мастеруудын холбооны төлөөлөл-1

10.6. Их хуралд оролцох төлөөлөгчийг дүрмийн 10.5 заасан тоонд багтаан зөвлөл, клубууд өөрсдөө сонгоно. Төлөөлөгчид нь Холбооны албан ёсны гишүүн байх ба гишүүний үүргээ биелүүлдэг байна.

10.7. Их хурлын төлөөлөгчдийн энгийн олонхи буюу 50%-аас дээш ирц бүрдсэн хурлыг хүчинтэйд тооцно.

10.8. Ерөнхийлөгч нь сонгуульт албан тушаалтныг сонгох болон дараагийн Их хурлын товыг тогтоохоос бусад асуудлаар санал тэнцсэн тохиолдолд саналын (таслах) эрхтэй оролцоно.

10.9. Их хурлын хэлэлцэж буй асуудлыг оролцогчдын энгийн олонхийн (50%-аас дээш) саналаар шийдвэрлэнэ.



10.10. Дор дурдсан асуудлаар Ерөнхийлөгчийн санаачлага эсвэл Удирдах Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх (2/3)-ийн саналыг үндэслэн ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж болно. Үүнд:

10.10.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нөхөн батлах,

10.10.2 Сонгуульт албан тушаалтнуудыг нөхөн сонгох,

10.10.3 Удирдах зөвлөлийн томилогдох албан тушаалтнуудын нөхөн томилгоог батлах,

10.10.4 Удирдах зөвлөлийн өргөн барьснаар Салбар холбоог татан буулгах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

10.10.5 Ээлжит бус Их хуралд оролцогчдын энгийн олонхи буюу 50%-с дээш бүрдсэн тохиолдолд тухайн хурлыг хүчинтэйд тооцно.

10.11. Ээлжит бус Их хуралд хэлэлцэж буй асуудлыг оролцогчдын энгийн олонхийн (50%-с дээш) саналаар шийдвэрлэнэ.

Арван нэг. СОНГОГДОХ БОЛОН ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ СОНГОХ, ТОМИЛОХ

11.1. МУССХ-ны Их хурлаас 30 хоногийн өмнө Удирдах зөвлөлийн хурлаар сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан комиссыг байгуулна.

11.2. Хараат бус комисс нь Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч бүртгэл хөтлөхөөс эхлэн сонгуулийн дүнг мэдээлэх хүртэлх Сонгуулийн бүхий л үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар хариуцан ажиллана.

11.3. Хараат бус комисс нь даргыг оролцуулсан гурван хүний бүрэлдэхүүнтэй байх ба эдгээр бүрэлдэхүүн нь нэр дэвших, санал өгөх эрхгүй байна. Комиссын бүрэлдэхүүнд хууль эрх зүйн мэргэжилтэй, туршлагатай этгээдийг заавал оролцуулна. Хараат бус гишүүн нь МУССХ-ны гишүүнээр элсэж байгаагүй этгээд байна.

11.4. Хараат бус, бие даасан комисс нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах түр журмыг Их хурлаас 15-с багагүй хоногийн өмнө боловсруулан гаргах ба Холбооны ажлын алба уг журмыг нийт гишүүдэд хүргэнэ.

11.5. Ерөнхийлөгч Их хуралд оролцож байгаа саналын эрхтэй оролцогчдын саналын эрхийн энгийн олонхоор (50% +1) сонгогдоно. Бусад сонгогдох

албан тушаалтнууд мандатын тоонд нийцүүлэн хамгийн олон санал авсан нэр дэвшигчид сонгогдоно. Дараах албан тушаалтнууд сонгогдох албан тушаалтан байна.

11.5.1 Ерөнхийлөгч буюу Удирдах зөвлөлийн дарга

11.5.2 Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

11.5.3 Дэд Ерөнхийлөгч

11.5.4 Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн;

11.5.5 Хяналтын зөвлөл

11.5.6 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нэгээс доошгүй (1) тамирчдын төлөөлөл заавал байна.

11.6. Удирдах зөвлөлөөс томилогдох албан тушаалтнуудыг Удирдах зөвлөлийн хурлын хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхоор (50%-с дээш) батална. Дараах албан тушаалтнууд томилогдох албан тушаалтан байна.

11.6.1 Ерөнхий нарийн бичгийн дарга,

11.6.2 Санхүүч.

11.7. Сонгуульт албан тушаалын сонгуульд нэр дэвшигч нь холбооны гишүүн байх ба дараах шаардлагыг хангасан этгээд байна.

11.7.1 Монгол Улсад усан спортыг хөгжүүлэх, Холбооны гишүүд, тамирчид, сонирхогчдын эрх ашгийг хамгаалах, Холбооны эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллах, Холбооны дүрэм, журмыг чандлан сахих чин эрмэлзэлтэй байх;

11.7.2 Урьд нь Холбооны болон бусад спортын холбоонд аливаа албан тушаал хаших хугацаандаа ёс зүйн болон санхүүгийн зөрчил гаргаж байгаагүй этгээд байх;

11.7.3 Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгчид нэр дэвших этгээд нь сүүлийн дөрвөн жил (4) Холбооны гишүүний хувьд үр бүтээлтэй идэвхтэй ажилласан, гишүүний татвараа хугацаанд нь тогтоосон хэмжээгээр төлсөн байх;

11.7.4 Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй байх

11.7.5 Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх

11.7.6 Хууль тогтоомж, холбооны дүрэм журамд заасан бусад шаардлагыг хангасан байх.

11.8. Сонгуулийг санал хураалтаар явуулна. Хэрвээ тухайн сонгуульт албан тушаалтны хяналтын тоо болон нэр дэвшигчийн тоо тэнцүү байх

тохиолдолд сонгуулийн санал хураалтыг ил явуулж болно. Бусад тохиолдолд саналын хуудас ашиглана.

11.9. Сонгуулийн хараат бус комисс нэр дэвшигчийн бүртгэлийг баталгаажуулсны дараа саналын хуудас хэвлэгдэж, нэр дэвшигчийн дэвших эрх нээгдсэнд тооцно.

11.10. Холбооны гишүүн холбооны удирдлагад өөрийн нэрийг дэвшүүлж бүртгүүлсэн тохиолдолд, бүртгэл хаагдсаны дараа, саналын хуудас хэвлэгдэх хүртэлх хугацаанд өөрийн хүсэлтээр нэр дэвшихээс татгалзах, өөрийн нэрийг дэвшүүлсэн албан тушаалын ангилалыг сольж өрсөлдөх эрхтэй.

11.11. Ийнхүү бүртгэл хаасны дараа, өөрийн нэрийг дэвшүүлсэн албан тушаалын ангилалыг солих тохиолдолд эрэмбийг (зөвхөн) бууруулж солих эрхтэй.

11.12. Хараат бус комисс сонгуулийн үйл явцын талаар саналын эрхтэй бүх гишүүдийн асуулт тодруулгад хариу өгөх, мэдээллээр хангах үүрэгтэй.

Арван хоёр. СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, ДҮНГ ГАРГАХ АРГАЧЛАЛ

12.1. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.

12.1.1 Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны дүрмийн 11.5 -д заасны дагуу Их хурлын төлөөлөгчдийн энгийн олонх буюу 50%+1 санал авсан тохиолдолд сонгогдоно.

12.1.2 Хэрэв нэр дэвшигчид 50%+1 дээш санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчдийн дунд дахин санал хурааж шийдвэрлэх бөгөөд ингэхдээ нийт саналын 50%+1 дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно.

12.2. Тэргүүн Дэд Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.

12.2.1 Тэргүүн Дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны Их хурлын төлөөлөгчдийн хамгийн олон санал авсан нэг (1) нэр дэвшигч, Дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны Их хурлын төлөөлөгчдийн хамгийн олон санал авсан дөрвөн (4) нэр дэвшигчид багтсан тохиолдолд сонгогдоно.

12.2.2 Хэрэв нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцэж, энэ нь сонгуулийн үр дүнд нөлөөлөхөөр байвал тэнцүү тооноос илүү санал

авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцож, зөвхөн тэнцүү тоотой санал авсан нэр дэвшигчдийн хооронд дахин санал хураалт явуулж, хамгийн олон саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.

12.3. Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.

12.3.1 Хамгийн олон санал авсан Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг мандатын тоонд нийцүүлэн сонгогдсонд тооцно.

12.3.2 Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь хамгийн олон санал авсан гурван нэр дэвшигчид багтсан тохиолдолд сонгогдоно.

12.3.3 Хэрэв Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн сонгуульд нэр дэвшигчдийн саналын тоо тэнцэж энэ нь сонгуулийн үр дүнд нөлөөлөхөөр байвал тэнцүү тооноос илүү санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцож, зөвхөн тэнцүү тоотой санал авсан нэр дэвшигчдийн хооронд дахин санал хураалт явуулж, хамгийн олон саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.

12.4. Санал өгөөгүй хоосон хуудас, саналын хуудсыг засварласан, илүү тэмдэглэгээ хийсэн, сонгуульт албан тушаалтан тус бүрийн тооноос илүү эсхүл дутуу тоогоор нэр дэвшигчид санал өгсөн бол уг саналыг хуудсыг хүчингүйд тооцно.

12.5. Их хурлын гишүүн санал өгөх явцдаа зөвхөн нэг удаа Хараат бус комисст хүсэлт гарган комиссын шийдвэрээр өмнөх саналын хуудсаа хүлээлгэн өгч, шинэ саналын хуудас сольж авах эрхтэй. Энэ тохиолдолд хуучин саналын хуудсыг устгаж энэ тухай тэмдэглэл хөтөлж албажуулна.

Арван гурав. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

13.1. Их хурлын чөлөөт цагт холбооны эрх барих байгууллага нь Удирдах Зөвлөл байна.

13.2. Удирдах зөвлөлийг Холбооны Их хурлаас дөрвөн (4) жилийн хугацаатайгаар сонгоно.

13.3. Удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

13.3.1 Ерөнхийлөгч- 1

13.3.2 Тэргүүн Дэд Ерөнхийлөгч – 1

13.3.3 Дэд ерөнхийлөгчид-4

13.3.4 Удирдах зөвлөл гишүүд - 9

13.3.5 Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл гучин (30) хувиас багагүй байх зарчмыг баримтална.



13.3.6 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд дор хаяж нэг (1) саналын эрхтэй тамирчны төлөөлөл заавал багтана.

13.4 Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

13.5 Холбооны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна.

13.6 Удирдах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа ердийн олонхийн ирцтэй хуралдаж, доорхи асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

13.6.1 Холбооны үйл ажиллагаа төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах;

13.6.2 Их хурлаас гарсан бүхий л шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

13.6.3 Салбар холбоо болон хороодын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонсож, хэлэлцэх, зөвлөмж өгөх, дүгнэх;

13.6.4 Олимп, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин, дасгалжуулагчийг батламжлах;

13.6.5 Олон улсын зэрэглэлийн бусад тэмцээнд Холбооны гишүүн тамирчныг олон улсад түгээмэл зарчмаар сонгон шалгаруулах, оролцуулах журмыг батлах;

13.6.6 Уралдаан, тэмцээн, сургалтын нэгдсэн хуваарийг батлах;

13.6.7 Холбоонд шинээр гишүүн болж элсэх хүсэлтээ гаргасан салбар холбооны гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх;

13.6.8 МУССХ-ны болон салбар холбоодын бүх албан тушаалтнуудыг богино, хугацааны сургалтад хамруулж, ажил үүрэгтэй нь холбоотой зөвлөмж чиглэлээр хангах;

13.6.9 Ажлын алба, санхүү, тэмцээн уралдааны тайланг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх;

13.6.10 Шагнал урамшуулалд нэр дэвшигчдийг батлах;

13.6.11 Холбооны Хүндэт Ерөнхийлөгчийг батламжлах;

13.6.12 Байгууллагын дотоод журам батлах;

13.6.13 Бусад

13.7 Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэр хуралд оролцогчдын энгийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. УЗ-ийн хурлын шийдвэр тогтоол хэлбэрээр гарч тогтоолд Ерөнхийлөгч гарын үсэг зурна.

13.8 Хурлын тэмдэглэлийг ЕНБД хөтөлж, 7 хоногийн дотор УЗ-н гишүүдэд цахим хаягаар нь илгээнэ.



Арван дөрөв. ХОЛБООНЫ УДИРДЛАГА

Ерөнхийлөгч

14.1. Ерөнхийлөгч нь Холбооны удирдах хамгийн дээд албан тушаалтан байх бөгөөд 30 нас хүрсэн Монгол улсын иргэн байна. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь Их хурлаар баталж 4 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

14.2. Ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.2.1 Холбооны үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах;

14.2.2 Холбоог Олон Улсын болон Үндэсний хэмжээнд албан ёсоор төлөөлөх;

14.2.3 Их хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг даргалах;

14.2.4 Их хуралд ажлаа тайлагнах;

14.2.5 Санхүүгийн баримтанд Нэгдүгээр гарын үсэг зурж, тайлан тэнцлийн үнэн зөвийг хариуцах;

14.2.6 МУССХ-ны нэрийн өмнөөс Усан спортын тамирчин, дасгалжуулагч, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хэлэлцээрийг батлах;

14.2.7 Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарын чиг үүргийг хуваарьлах

14.2.8 Холбооны Хүндэт Ерөнхийлөгчөөр өргөмжлөх иргэнийг УЗ-д санал болгон батламжлуулах;

14.2.9 Холбооны үйл ажиллагаанд шаардлагатай зарим бүтцийг байгуулах буюу ажлын албыг томилох, чөлөөлөх (Ажлын алба нь сургалт, судалгаа явуулах, мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх, уралдаан тэмцээний мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.

14.2.10 Салбар холбооны тэргүүнээр сонгогдсон этгээдийг батламжлах

14.3. Ерөнхийлөгч албан үүргээ түр, эсвэл бүр мөсөн гүйцэтгэх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд дараагийн ээлжит Их хурал болтол түүний эрх, үүргийг Тэргүүн Дэд Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ.

14.4. Холбооны Ерөнхийлөгчөөр ажиллах хугацаандаа Холбооны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан этгээдийг "Хүндэт Ерөнхийлөгч" өөр өргөмжилнө.



Хүндэт Ерөнхийлөгч

14.5. Хүндэт Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5.1 Холбооны бүхий л үйл ажиллагаанд урилгагүй оролцох

14.5.2 Холбооны Их хуралд саналын эрхтэй оролцох

14.5.3 Удирдах зөвлөлийн хуралдаанд саналын эрхгүй оролцох

14.5.4 Ерөнхийлөгчид зөвлөн туслах

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

14.6. Тэргүүн Дэд Ерөнхийлөгч нь усан спортын аль нэг хороог ахлан ажиллах бөгөөд дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

14.6.1 Холбооны Ерөнхийлөгчийн эзгүйд Холбоог төлөөлөх

14.6.2 Холбооны дүрмийн хүрээнд Ерөнхийлөгчийн хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэх

Дэд ерөнхийлөгч

14.7. Холбооны Их хурлын төлөөлөгчдийн санал хураалтаар хамгийн олон санал авсан дөрвөн нэр дэвшигчийг 4 жилийн хугацаатайгаар Холбооны Дэд Ерөнхийлөгчид сонгогдсонд тооцно.

14.8. Холбоо нь дөрвөн (4) Дэд Ерөнхийлөгчтэй байна.

14.9. Дэд Ерөнхийлөгч нь Усан спортын аль нэг төрлийн салбар хороог ахлаж, тус спортыг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж, үр дүнг Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Их хуралд танилцуулж, тайлагнана,

14.10. Удирдах зөвлөл болон хариуцсан салбар хороог мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажиллах,

14.11. Хариуцан ажиллаж байгаа чиглэлээрээ Салбар хорооны уг асуудлыг эрхэлсэн албан тушаалтнуудтай үр бүтээлтэй хамтран ажиллах,

14.12. Салбар хорооны удирдлагад зөвлөж, туслах, тэдгээрт сургалт зохион байгуулах, тухайн салбар хороо болон МУССХ-ны хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааг үр дүнтэй байлгах бүх талын арга хэмжээ авах.

Ерөнхий нарийн бичгийн дарга:

14.13. Ерөнхийлөгчийн шууд удирдлагад ажиллаж, холбооны стратеги төлөвлөгөө болон Ерөнхийлөгчийн бодлогыг хэрэгжүүлэгч гол албан тушаалтан байна.



14.14. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дээд боловсролтой, усан спортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, мэргэшсэн, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвар, туршлагатай байна.

14.15. Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлийн хурлаар сонгож, чөлөөлөх бөгөөд орон тооны байна.

14.16. Ерөнхий нарийн бичгийн даргын эрх, үүрэг:

14.16.1Их хурал, Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, Удирдах зөвлөлд ажлаа тайлагнах, санал оруулах,

14.16.2Их хурал, УЗ-ийн хурал бусад зөвлөлүүдийн хурлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжилтийг хангах, гишүүдийг мэдээллээр хангах,

14.16.3Дасгалжуулагч, тамирчинтай гэрээ, хэлцэл хийх,

14.16.4Холбооны үйл ажиллагааны харилцааг зохицуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах дүрэм журам, Жилийн ажлын болон спорт, тэмцээний календарчилсан төлөвлөгөө, төсөв, орон тоо, бодлогын чанартай бичиг баримтыг боловсруулан бэлтгэж, Удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх,

14.16.5Удирдах зөвлөлийн дэргэдэх зөвлөл, багийг өдөр тутмын удирдлагаар хангаж, хамтран ажиллах, тэдний асуудлыг холбогдох хүмүүст танилцуулж шийдвэрлүүлэх,

14.16.6Холбооны үйл ажиллагаа, усан спортын уралдаан тэмцээнийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод сурталчлах,

14.16.7Гадаад харилцааг өргөжүүлэх үйл ажиллагаа бодитой явуулах,

14.16.8Холбооны тэмдэг, туг далбаа, бичиг баримт, бусад зүйлсийг үйл ажиллагаанд ашиглах, хадгалах, хамгаалах, архивлах, өмч хөрөнгийг бүртгэн хяналт тавих,

14.16.9Жилийн эцсийн ажлын болон санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулж, Удирдах зөвлөлийн хуралд оруулах

14.16.10 Гадаад, дотоодод зохион байгуулагдах тэмцээнийг хариуцаж ажиллах

14.17. Ерөнхий нарийн бичгийн дарга нь ажлын албатай байж болох бөгөөд тус албыг удирдлагаар ханган ажиллана.



Санхүүч

14.18. Санхүүч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.18.1 Гишүүдийн татвар төлөлтийг хариуцан бүртгэх,

14.18.2 Холбооны санхүүгийн бүртгэлийг хөтөлж, хадгалалт хамгаалалтыг хариуцах,

14.18.3 Холбооны бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах бэлтгэл ажлыг хариуцаж, улирал тутамд тайланг мэдээлэх,

14.18.4 Их хуралд Холбооны санхүүгийн тайланг тайлагнах,

14.18.5 Жилийн тайлан тэнцэл, үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд гаргаж өгөх,

14.18.6 Удирдах зөвлөлийн баталсан төсвийн хүрэээнд, Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлийн дагуу мөнгөн зарлагыг гүйцэтгэх,

14.18.7 Дараа жилийн төсвийн төслийг бэлтгэн танилцуулах.

14.18.8 Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд шаардлагатай журам, зааврыг Ерөнхий нарийн бичгийн даргын хамтаар боловсруулж Удирдах зөвлөлд танилцуулж, батлуулах.

Арван тав. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ, БАГ

15.1. Холбооны Удирдах Зөвлөлийн дэргэд дараах Зөвлөл, баг ажиллана.

15.2. Дасгалжуулагчдын зөвлөл:

15.2.1 Зөвлөлийн бүрэлдэхүүнд олон улс, тив, дэлхий, Олимпийн наадамд тамирчид нь шалгаран оролцдог, үндэсний шигшээ багийн тамирчдыг дасгалжуулдаг, аль нэг клубт тамирчдынхаа өдөр тутмын бэлтгэл, сургалтыг тогтмол хариуцдаг мэргэжлийн дасгалжуулагчид орно.

15.2.2 Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.

15.2.3 Дасгалжуулагчдын зөвлөлд 7 (долоо) хүн байна. Өөрийн бүрэлдэхүүнээс зөвлөлийн даргыг нууц санал хураалтаар ердийн олонхийн зарчмаар сонгож, Холбооны Удирдах зөвлөлд санал оруулж батлуулна. Дасгалжуулагчдын зөвлөлийн дарга нь үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчид нэр дэвшинэ.

15.3. Шүүгчдийн зөвлөл:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭГЧ
520
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

15.3.1 Холбооноос баталсан төлөвлөгөөний дагуу дотоодод зохиогдох тэмцээнд ажиллах шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох, бэлтгэх, заавар зөвлөмж өгөх, Олон улсын усан спортын холбоо (World Aquatics)-ны дүрмийг хэрэгжүүлэх, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг дасгалжуулагч, тамирчдад тухай бүр танилцуулж мөрдүүлэх үүрэгтэй.

15.3.2 Холбооны Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.

15.3.3 Шүүгчдийн зөвлөл нь 5 (тав) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнээсээ даргаа нууцаар санал хураан сонгож, Удирдах зөвлөлд оруулж, батлуулна.

15.4. Тамирчдын зөвлөл:

15.4.1 Усан спортын тамирчдын эрх ашгийг хамгаалах, тэдний эрүүл мэнд, нийгмийн асуудлыг анхаарч тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж, туслах үүрэгтэй.

15.4.2 Тамирчдын хурлаар 5 (тав) хүнийг зөвлөлийн гигүүнээр сонгож, гишүүдийнхээ хурлаар даргаа нууц санал хураан сонгоно. Удирдах зөвлөлөөр батлуулна. Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.

15.5. Ёс зүйн зөвлөл:

15.5.1 Холбооны гишүүдийн ёс суртахууны харилцааг зохицуулж, тэдний дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоон ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, Холбооны гишүүдийн нэр төрийг хамгаалах үүрэгтэй. Холбоо нь ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд дүрмийг Ёс зүйн зөвлөлөөс санал болгосоноор Удирдах зөвлөл батална.

15.5.2 Ёс зүйн зөвлөлийг Удирдах зөвлөлөөс байгуулна.

15.5.3 Ёс зүйн зөвлөл нь дотоод журмаа Удирдах зөвлөлөөр батлуулан мөрдлөг болгож ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 5 (тав) хүний нэрийг дэвшүүлж, бүрэлдэхүүнээсээ даргаа нууцаар санал хураан сонгон, Удирдах зөвлөлөөр батлуулна.

15.6. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны баг:

15.6.1 Усан спортын статистик судалгаа гаргах, сургалт дасгалжуулалтын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж, дасгалжуулагч, тамирчдын ажиллах арга барилд дүн шинжилгээ хийж, зааварчилга өгөх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл, үр өгөөжийг

УЛСЫН БҮРТГЭГЧ 520

дээшлүүлж, монгол хүний онцлогт тохирсон дасгалжуулалтын арга, технологийг бэлтгэн, сургалт явуулах, судлаж боловсруулахад ажлаа чиглүүлнэ.

15.6.2 Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны баг нь 5 (тав) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ахлагч нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, эрдмийн ажил туурвисан, магистр болон түүнээс дээш цолтой байна. Өөрийн бүрэлдэхүүнээсээ багийн ахлагчаа нууцаар санал хураан сонгож, дотоод журам, ажлын чиглэлийг Удирдах зөвлөлөөр батлуулна.

15.7. Гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгаа, технологийн баг:

15.7.1 Холбооны олон талт болон хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

15.7.2 Холбооны үйл ажиллагаа, усан спортыг Холбооны вэб хуудас, бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчилна.

15.7.3 Удирдах зөвлөл болон дасгалжуулагч, тамирчдыг усан спортын холбогдолтой шинэ мэдээллээр хангана.

15.7.4 Гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгааны багийн ахлагч нь мэргэжлийн ажлын дадлага, туршлагатай байх бөгөөд Удирдах зөвлөлөөс бүрэлдэхүүн, ахлагчийг томилон ажиллуулна.

15.7.5 Холбооны тэмцээн, арга хэмжээний үеийн техник технологийн асуудлыг хариуцан ажиллана.

Арван зургаа.ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

16.1. Хяналтын Зөвлөлийг Холбооны Их Хурлын төлөөлөгчдийн мандатын тоонд нийцүүлэн нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг сонгох бөгөөд зөвлөл нь Их Хурлын хугацаагаар сонгогдоно.

16.2. Хяналтын Зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллан Зөвлөлийн хурлаас даргыг сонгоно.

16.3. Хяналтын Зөвлөл нь Холбооны үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

16.4. Хяналтын Зөвлөл нь Удирдах Зөвлөлийн хуралд зөвлөх эрхтэй оролцож болно.

16.5. Холбооны хяналтын үйл ажиллагааг Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

16.6. Хяналтын зөвлөл нь Холбооны хөрөнгө, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, удирдах бүрэлдэхүүн, дасгалжуулагч, тамирчин, шүүгчдийн ёс зүй,

УЛСЫН БҮРТГЭГЧ 520

Удирдах зөвлөлийн хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн тушаал, Холбооны дүрэм, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтэнд хяналт тавьж, шаардлагатай бол шалгалт явуулна.

16.7. Санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

16.8. Холбооны үйл ажиллагаанд хийсэн шалгалт, хүсэлт, өргөдөл гомдлыг зөвлөлөөрөө хэлэлцэн шийдвэрлэх, Холбооны Ерөнхийлөгчид танилцуулж, Удирдах зөвлөлийн хуралд оруулж, шаардлагатай гэж үзвэл хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

Арван долоо.ЛИЦЕНЗ

17.1. Лицензи гэдэг нь зөвхөн Холбооноос тусгай батлагдсан журмын хүрээнд олгогдох эрх, батламж, гэрээг хэлнэ.

17.2. Лицензийг холбооны дүрмийн болон бусад зөрчилгүй дараах этгээд эзэмшинэ. Үүнд:

17.2.1 Дасгалжуулагч

17.2.2 Клубын тамирчин

17.2.3 Шүүгч

17.3. Бие даасан клубүүд лицензи эзэмшигч байж болох ба энэ төрлийн харилцааг Удирдах зөвлөлөөс баталсан гэрээгээр зохицуулна.

17.4. Лиценз нь үүрэг зориулалтаас хамаарсан тус тусын үнэтэй байна.Үнийг Удирдах зөвлөлөөс тогтооно.

Арван найм. ДОПИНГИЙН ХЯНАЛТ

18.1. Холбоо нь ОУОХ-ны дүрэм, Дэлхийн, Допингийн Эсрэг Агентлагийн дүрэм (WADA), Олон улсын холбооны дүрэмд допингийн эсрэг тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн Допингийн эсрэг дүрэмтэй байна

18.1.1 Допингийн эсрэг Олон улсын болон Үндэсний байгууллагуудтай хамтран ажиллаж, тогтмол мэдээлээ солилцох

18.1.2 Допингийн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах

18.1.3 Допинг хэрэглэсэн тохиолдолд авах арга хэмжээ авах

Арван ес. ХОЛБООНЫ ЭД ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

19.1. Холбоо өөрийн мөнгөн сан, эд хөрөнгөтэй байна. Үүний эх үүсвэрийг дараахи хэлбэрээр бүрдүүлнэ:

19.1.1 Гишүүдийн татвар

19.1.2 Дотоод, гадаадын байгууллага, хувь хүний хандив

19.1.3 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны орлого

19.1.4 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс болон олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө

19.1.5 Төрийн байгууллагын санхүүгийн дэмжлэг

19.2. Холбооны гишүүн, байгууллага, клуб, хувь хүн жилд нэг удаа,жил бүрийн 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор, тогтоосон хэмжээгээр татвар төлнө. Холбооны хүндэт гишүүн татвараас чөлөөлөгдөнө.

19.3. Гишүүний татварын хэмжээг Удирдах Зөвлөлөөс тогтоосон хязгаарын дотор жил бүр тогтооно.

19.4. Гишүүн элсэхэд тэмдэгтийн хураамж, үнэмлэхний үнийг гишүүд төлсөн байна. Гишүүдийн татвар, хандивын орлогыг Холбооны дансанд шилжүүлсэн байна.

19.5. Холбоо нь банкинд төгрөгийн болон валютын, данстай байна.

19.6. Данстай харьцах эрхийг Холбоонд Ерөнхий нарийн бичгийн дарга болон санхүүч эдлэнэ.

19.7. Холбоо нь төвлөрсөн сантай байж болох бөгөөд түүнийг зарцуулах журмыг Удирдах Зөвлөл батлана.

19.8. Холбооны хөрөнгө, санхүүгийн тайлан тэнцэл нь ил тод байна.

19.9. Энэ дүрмийн 5.13-д заасан эх үүсвэрийг Холбооны дансанд төвлөрүүлнэ.

19.10. Усан спортын үйл ажиллагаатай холбоотойгоор Холбооны гишүүн клуб, тамирчин, салбар холбоо, хороо болон бусад гишүүнд олгосон бүх төрлийн санхүүжилт, мөнгөн хандив, дэмжлэгийг Холбооны нэгдсэн дансаар хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулна. Санхүүжилтийг хүлээн авах, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг Удирдах зөвлөл батална. Орлого, зарцуулалтыг санхүүжилт хүлээн авагч болон төсөл, арга хэмжээ тус бүрээр бүртгэж, тайлагнана.

Хорь. ХОЛБООНЫ ЯЛГАРАЛ

20.1. Холбоо нь бэлгэдэл (лого), туг, энгэрийн тэмдэгтэй байна.

20.2. Холбооны бэлгэдэл, тугийн загвар, хэрэглэх журмыг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар батална.

20.3. Холбооны бэлгэдэлийг Холбооны салбар холбоод нь туг, зураг хуудас, ном, албан бичиг болон веб хуудас, зүүлт, хаяг, медаль, дурсгалын тэмдэг,

дарцаг, багийн бүрэлдэхүүний болон шүүгчдийн хувцас, хэрэглэл, ном сэтгүүл зэрэгт хэрэглэх бөгөөд МУССХ-ны гишүүн холбоо, клуб болон албан ёсны гэрээт түнш байгууллага мөн нэгэн адил хэрэглэж болно.

20.4. Холбооны шигшээ багийн бүрэлдэхүүн, шүүгчид нь дотоодод болох тэмцээнд холбооны лого, Холбооны шүүгч гэсэн бичиг бүхий дүрэмт болон багийн хувцастай байна. Дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг Удирдах зөвлөл тогтооно.

20.5. Холбоо нь өөрийн Дээд шагналтай байна. Шагналын нэр, хэлбэр, олгох болзол журмыг Удирдах зөвлөлөөс тогтооно.

20.6. Холбооны цахим хуудас, ЕНБД-ны холбоог төлөөлж бусад байгууллагатай харилцах цахим хаяг, домэйн зэрэг Холбооны өмч байна.

Хорин нэг. ХОЛБООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

21.1. Холбооны үйл ажиллагааг зогсоох, эд хөрөнгийг хэрхэх асуудлыг "Төрийн бус байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 1-р бүлгийн 7-р зүйлийн 2, 3 дахь заалтын дагуу Холбооны Их Хурал шийдвэрлэнэ.

21.2. Энэхүү дүрэм 2026 оны 10 дугаар сарын 10 -ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО НҮТББ-ЫН ЭЭЛЖИТ ИХ ХУРАЛ

2026 оны 10 дугаар сарын 10-ны өдөр